



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/363

Улаанбаатар хот

Шатахууны норм батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны "Жишиг норм батлах тухай" 390 дүгээр тушаал, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 3.2.19, 3.2.20 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын шаардагаар худалдан авсан КО-829А1 /Камаз – 740.31-240/ маркийн 10857 см.куб хөдөлгүүрийн багтаамжтай аэродром талбайн арчилгаа, цэвэрлэгээ, үйлчилгээний автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны үндсэн нормыг дизель түлш - 40 литр, тоноглол ажиллуулахад 1 мото/цагт зарцуулах шатахууны үндсэн нормыг дизель түлш - 12.5 литрээр тооцон тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг батлагдсан өдрөөс мөрдөж ажиллахыг Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба (Б.Батбаатар)-нд, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Нисэх буудлуудын үйлчилгээний газар (С.Нацагдорж)-т, Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Б.Батхишиг)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Л.Тайванжаргал)-т даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ